



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО



СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Санхүүгийн зохицуулалттай салбарууд дахь комплайнсын
хяналтын тогтолцооны өнөөгийн байдал

2023



www.frc.mn

Өмнөх үг

Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахын тулд компанийн засаглалаас гадна комплайнсын удирдлагыг хэрэгжүүлдэг олон улсын сайн туршлага бий. Харин манай улсад банкнаас бусад санхүүгийн салбарын комплайнсын өнөөгийн байдлыг үнэлж, дүгнэсэн судалгааны ажил ховор байгаа ба энэ судалгаа нь банкнаас бусад санхүүгийн зохицуулалтай салбарын комплайнсын тогтолцооны өнөөгийн байдал, цаашид тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлох үндэслэл болсон ба энэ чиглэлд хийгдсэн анхны судалгаа болж байна.

Энэхүү судалгааг Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны захиалгаар Санхүү Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС)-ийн судалгааны баг, СЗХ-ны Компанийн Засаглал, Комплайнсын хэлтэс хамтран гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго

СЗХ-ны зохицуулалттай санхүүгийн байгууллагуудын комплайнсын тогтолцооны өнөөгийн байдлыг дүгнэх, цаашид тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж гаргах.


Судалгааны арга зүй

“Ernst&Young” үнэлгээний байгууллагын 2021 онд хийсэн “Комплайнсын эрсдэлийг үнэлэх” судалгаа болон онолын судалгаанд үндэслэн нийт 5 бүлэг, 35 асуулт бүхий судалгааны асуулгыг 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс мөн оны 8 дугаар сарын 21-ний хооронд даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ, хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК) болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ)-ээс санал асуулгын хэлбэрээр авав. Судалгааны асуулгын агуулга нь дараах бүтэцтэй. Үүнд:

1. Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, комплайнсын хяналтын тогтолцоо
2. Комплайнсын хамрах хүрээ, соёл
3. Комплайнсын бүтэц
4. Комплайнсын үйл ажиллагаа
5. Цахим хэрэглээ, сургалт

Хамрах хүрээ

Судалгаанд СЗХ-ны зохицуулалтын салбарын 76.5 хувь нь буюу 145 байгууллагаас 111 нь хамрагдав. Үүнээс, Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ 66, ХОМК 18, Даатгагч 16, ВХҮҮ 11 байгууллага судалгаанд хамрагджээ. Судалгаанд ВХҮҮ байгууллагаас 100.0 хувь, даатгалын байгууллагаас 89.0 хувь, ББСБ-аас 84.0 хувь, ХОМК-аас 49.0 хувь нь хамрагдсан ба хангалттай хэмжээний түүвэр судалгааг авсан.



Судалгааны үр дүнгээс судалгаанд хамрагдсан албан тушаалтнуудыг авч үзвэл, гүйцэтгэх захирал 29.0, эрсдэл хариуцсан захирал, мэргэжилтэн 13.0, комплайнс хариуцсан захирал, мэргэжилтэн 22.0, санхүү 9.0, хууль 4.0, дотоод аудитор 9.0, бусад чиг үүрэг хариуцсан мэргэжилтнүүд 8.0 хувийг тус тус эзэлсэн бүтцийг үзүүлэв.

Судалгаанд хамрагдсан байгууллагын дийлэнх буюу 53.0 хувь нь 6-15 жил ажилласан, 30.0 хувь нь 5 хүртэл, үлдсэн хэсэг нь 16-аас дээш жил ажилласан ажлын туршлагатай байна. Харин нийт ажиллагсдын тоогоор авч үзвэл 50.0 хувь нь 10 хүртэл, гуравны нэг нь 50 хүртэл, 20 орчим хувь нь 50-аас дээш ажилтантай байна. Тухайн компанийн үйл ажиллагаа явуулсан туршлага, нийт ажиллагсдын тооноос хамааран комплайнсын хяналтыг хэрэгжүүлэгч бүтэц, ажлын дотоод зохион байгуулалт харилцан адилгүй байв.

Хэсэг 1.

Компанийн
засаглал,
эрсдэлийн
удирдлага,
комплайнсын
хяналтын
ТОГТОЛЦОО



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

64.0%

Судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагуудын 64.0 хувь нь Компанийн засаглалын тогтолцоог хэрэгжүүлж хэвшсэн, 20.0 хувь нь хэрэгжих эхний шатандаа байгаа, цаашид сайжруулах шаардлагатай

56.0%


Эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдсэн гэж үзсэн ба 23.0 хувь нь сайжруулах шаардлагатай

59.0%

Комплайнсын хяналтын тогтолцоо бүрдсэн гэж үзсэн ба 18.0 хувь нь сайжруулах шаардлагатай

Дүгнэхэд, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах хэрэгцээ шаардлагатай

Зураг 1.1 Компанийн засаглал, комплайнсын хяналт, эрсдэлийн удирдлага хэрэгжилт /салбараар/




Санхүүгийн зохицуулалттай салбараас ББСБ болон ХОМК-ууд компанийн засаглалын тогтолцоогоо илүү сайн хэрэгждэг гэж хариулжээ. Бусад салбартай харьцуулахад, ВХҮҮ-ийн салбарт компанийн засаглалын тогтолцоог сайжруулах шаардлагатай гэж дүгнэхээр байна.


Даатгагч, ХОМК-уудад эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо бусад салбартай харьцуулахад илүү сайн бүрдсэн дүгнэжээ.

Зураг 1.2 Компанийн засаглал, Комплайнсын хяналт, Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт


Манай байгууллагад компанийн засаглалын тогтолцоо бүрэн хэрэгжиж хэвшсэн



Манай байгууллагад эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрэн хэрэгжиж хэвшсэн



Манай байгууллагад комплайнсын удирдлагын тогтолцоо бүрэн хэрэгжиж хэвшсэн



- Хариулах боломжгүй
- Хэрэгжиж эхлэх эхний шатдаа байна
- Сайжруулах шаардлагатай
- Дундаж түвшинд
- Санал нийлнэ
- Бүрэн санал нийлнэ

ВХҮҮ байгууллагууд хамгийн өндөр буюу тэдгээрийн 73.0 хувьд нь комплайнсын хяналтын тогтолцоо бүрдсэн гэсэн бол даатгагч 63.0, ББСБ 58.0, хамгийн бага буюу ХОМК-уудын 56.0 хувь нь комплайнсын хяналтын тогтолцоог бүрдүүлсэн гэсэн байна.

Судалгаанд оролцогсдын 20.0 хувь нь компанийн засаглал, эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтын тогтолцоог улам сайжруулах шаардлагатай гэж хариулжээ.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН БҮРДЭЛ

70.3%

Комплайнсын бүрдэл хэсгүүдийн хэрэгжилт хангалттай

79.3%

Харилцагчийн мэдээллийг нууцлах, харилцагчаа таньж мэдэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, дотоод хяналтын тогтолцоог үр дүнтэй хэрэгжиж хэвшсэн

64.9%

Мэдээллийн аюулгүй байдал, санхүүгийн гэмт хэрэг, луйврыг илрүүлэх үр дүнтэй тогтолцоо бүрдсэн

Зураг 1.3 Комплайнсын бүрдэл хэсгийн хэрэгжилт



Комплайнсын бүрдэл хэсгүүд болох 6 үндсэн үзүүлэлтээр хэрэгжилт хангалттай эсэхийг тодруулахад дунджаар 70 орчим хувь нь уг тогтолцоог бүрдсэн гэж үзжээ.

ББСБ болон даатгалын компаниудын үр дүн ойролцоо гарсан бөгөөд харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал, тэдгээрийг таньж мэдэх, дотоод хяналт, мөнгө угаахтай тэмцэх тогтолцоо илүү сайн бүрдсэн гэжээ.

Хүснэгт 1.1 Комплайнсын бүрдэл хэсгийн хэрэгжилт /салбараар/


Комплайнсын бүрдэл хэсэг	ББСБ	ВХҮҮ	Даатгагч	ХОМК
Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо	66.7%	81.8%	62.5%	50.0%
Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх удирдлагын тогтолцоо	72.7%	81.8%	68.8%	55.6%
Санхүүгийн гэмт хэрэг, луйврыг илрүүлэх тогтолцоо	62.1%	72.7%	68.8%	61.1%
Харилцагчийг таньж мэдэх тогтолцоо	69.7%	90.9%	75.0%	61.1%
Харилцагчийн мэдээллийг нууцлах тогтолцоо	80.3%	100.0%	81.3%	61.1%
Дотоод хяналтын тогтолцоо	74.2%	81.8%	68.8%	61.1%
Дундаж	71.0%	84.8%	70.8%	58.3%

ВХҮҮ байгууллагын дийлэнх нь комплайнсын удирдлагын хүрээнд хийж буй ажлууд бүрэн тодорхойлогдсон, тогтолцоо бүрдсэн гэдэгтэй санал нэгджээ.

ХОМК-ийн судалгааны үр дүнгээс харахад байгууллага мэдээллийн аюулгүй байдал, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд анхаарал хандуулах, сайжруулах шаардлагтай гэж харагдаж байгаа ба бусад салбартай харьцуулахад ХОМК-уудад комплайнсын тогтолцоог бэхжүүлэх хэрэгцээ нэгэнт үүсээд байна.

Хэсэг 2.

**Комплайнсын
ТОГТОЛЦОО,
байгууллагын
соёл**



КОМПЛАЙНСЫН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БҮТЭЦ

9%


Комплайнсын нэгжтэй. Комплайнсыг байгууллагын засаглал, стратегийн нэг чухал хэсэг гэж үздэг тул дээд удирдлагын дэмжлэг, оролцоо их байдаг. Хангалттай хэмжээний орон тоо, төсөвтэйгөөр үйл ажиллагаагаа явуулдаг

89.2%

Комплайнс хариуцсан ажилтантай

Эдгээрээс хагас нь цаашид комплайнсын үр дүнтэй удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор үйл ажиллагааг нь тэлэх шаардлагатай гэж үзэн холбогдох төсөв, орон тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа, үлдсэн 38.7 хувь нь сайжруулах төлөвлөгөөтэй

Зураг 1.4 Комплайнсын нэгж, ажилтантай байгууллага



Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч 11 байгууллагаас 9 нь буюу 81.8 хувь нь комплайнсын нэгж, ажилтантай байна. Даатгалын компаниудын 62.5 хувь нь комплайнсын удирдлагыг хэрэгжүүлэх нэгж, ажилтантай бол ББСБ болон ХОМК-уудын хувьд 50 хүрэхгүй хувь нь энэ чиглэлийг хариуцсан бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 1.5 Комплайнсын удирдлага



Судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагуудаас комплайнсыг хэрэгжүүлэх шаардлагагүй эсвэл энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлд одоогоор анхаарал хандуулаагүй байгууллага байсангүй. Санхүүгийн салбарт комплайнсын удирдлагыг хэрэгжүүлэх үндэс суурь тавигдсан, цаашид хөгжүүлэх чиглэлээр төлөвлөсөн ажлууд хийгдэж байна гэж дүгнэхээр байна.

КОМПЛАЙНСЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ

51.4%

Комплайнсын тусдаа хөтөлбөр боловсруулж, дээд удирдлагаараа батлуулан ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг ба тогтмол сайжруулалт хийж, тухай бүр хяналт тавин ажилладаг


25.2%

Комплайнсын хөтөлбөр, ажлын төлөвлөгөөг баталсан боловч хэрэгжүүлэхэд хүний болон санхүүгийн нөөц дутмаг байдгаас бүрэн хэрэгждэггүй

18.0%

Комплайнсын хөтөлбөр, төлөвлөгөөг тусгайлан батлуулаагүй боловч комплайнсын эрсдэлд хяналт тавьж ажилладаг

Зураг 1.6 Комплайнсын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт



ВХҮҮ болон даатгалын компаниудын 70 орчим хувь нь комплайнсын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлдэг. Харин ББСБ болон ХОМК-уудын 48.5, 33.3 хувь нь комплайнсын хөтөлбөр, төлөвлөгөөтэй гэж тус тус хариулжээ. Эндээс ББСБ болон ХОМК-ууд комплайнсын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлд анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна.

Зураг 1.7 Комплайнсын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байдал



Судалгаанд хамрагдсан байгууллагуудын дөнгөж 1.0 хувь комплайнсын хөтөлбөр, ажлын төлөвлөгөөгүй гэж хариулсан бол 5 орчим хувь нь ойрын хугацаанд хөтөлбөр, ажлын төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байгаа аж.

Дээрхээс санхүүгийн зохицуулалттай салбарт 76 гаруй хувь нь комплайнсын хөтөлбөр, ажлын төлөвлөгөөтэй, 18 хувь нь тусгайлан комплайнсын төлөвлөгөө гэж батлуулаагүй ч комплайнсын тогтолцооны суурь тавигдсан гэж дүгнэж болохоор байна.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТ БА ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)

27.9%

Комплайнсын хяналт, түүний үр дүн, гүйцэтгэлийг ТУЗ-ийн хурлаар тогтмол хэлэлцдэг ба комплайнсын эрсдэлд өртөх боломжит тохиолдлуудыг ТУЗ-өөр хэлэлцүүлж, дотоод дүрэм, журамдаа тогтмол өөрчлөлт оруулдаг


52.3%

Комплайнсын эрсдэлийн асуудлаар шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, зарим тохиолдолд бичгээр мэдээлэл хүргүүлж, санал авдаг

3.6%

ТУЗ-өөр комплайнсын эрсдэлийн талаар хэлэлцдэггүй

Зураг 1.8 Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд ТУЗ-ийн оролцоо



ВХҮҮ байгууллагуудын 54.5 хувь нь буюу хамгийн өндөр хувь нь комплайнсын хяналтад ТУЗ-ийн оролцоо сайн гэж хариулжээ. Харин даатгагч, ХОМК-уудын гуравны нэг нь л ТУЗ-ийн оролцоог сайн гэж дүгнэсэн байна. Хамгийн бага үзүүлэлттэй нь ББСБ байгаа ба дөнгөж 22.7 хувь комплайнсын эрсдэлийн талаар ТУЗ-ийн түвшинд хэлэлцэж, шийдвэрлүүлж, үр дүнг танилцуулдаг тогтолцоотой гэжээ. Комплайнсын хяналтын тогтолцоонд ТУЗ-ийн оролцоо их байх нь хэрэгжилт үр дүнтэй байх үндэслэл болдог.

Зураг 1.9 Комплайнсын хяналт ба ТУЗ-ийн оролцоо



Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 80 орчим хувь нь ТУЗ-ийн түвшинд комплайнсын эрсдэлээ хэлэлцдэг гэж хариулсан нь санхүүгийн салбарт комплайнсын асуудлыг дээд удирдлагын түвшинд ач холбогдол өгч байгааг харуулж байна. Харин 16 орчим хувь нь комплайнсын эрсдэл үүссэн тохиолдолд ТУЗ-ийг зөвхөн мэдээллээр хангадаг гэжээ.

КОМПЛАЙНСЫН ТАЙЛАГНАЛ

67.6%


Байгууллагын комплайнсын хяналтын өнөөгийн нөхцөл байдал, үр дүнгийн талаар гүйцэтгэх удирдлага, ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд хагас жилдээ нэг болон түүнээс дээш удаа тайлагнадаг

89.2%

Комплайнсын нэгж, ажилтны дүгнэлтийг ТУЗ шийдвэр гаргалтандаа онцгойлон харгалзах хэрэгтэй


Энэ нь санхүүгийн зохицуулалттай салбарт комплайнсын ач холбогдлыг ойлгож, дээд удирдлагын түвшинд анхаарал хандуулж буйг харуулж байгаа бол санал нийлэхгүй, мэдэхгүй гэсэн хариулт 10 орчим хувийг эзэлжээ

Зураг 1.10 Комплайнсын тайлагнал



Улиралд нэгээс дээш удаа комплайнсын үр дүнг тайлагнадаг байгууллагууд 46 орчим хувийг эзэлж байгаа ба энэ тогтолцоо 6-аас дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа, 10-аас дээш ажилтантай байгууллагуудад бүрдсэн байна. Комплайнсын хяналтын тогтолцоо бүрдсэн гэдэгтэй ВХҮҮ байгууллагуудын дийлэнх хэсэг нь санал нийлж байсан боловч тайлагналын хувьд дөнгөж 20 хүрэхгүй хувь нь улиралд нэгээс дээш удаа комплайнсын асуудлаа тайлагнаж хэлэлцүүлдэг байна.

Зураг 1.11 Танай байгууллагын ТУЗ шийдвэр гаргалтад "Комплайнсын алба нэгж, ажилтны дүгнэлтийг харгалзан үзэх" гэдэгтэй санал нийлэх үү?



Судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагуудын 1 хүрэхгүй хувь нь комплайнсын нэгж, ажилтны дүгнэлтийг ТУЗ шийдвэр гаргахдаа харгалзан үзэх шаардлагагүй, огт санал нийлэхгүй гэсэн хариулт байхгүй, 9.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Судалгааг дийлэнхдээ эрсдэлийн удирдлагын алба нэгжийн харьяалалтай албан тушаалтнууд бөглөсөн байна.

Хэсэг 3.

**Комплайнсын
хяналтын
бүтэц**



КОМПЛАЙНСЫН НЭГЖ/АЖИЛТНЫ ХАРЬАЛАЛ

40.5%

Комплайнсын ажилтан эрсдэлийн болон хууль эрхзүйн нэгжээс өөр нэгжид харьяалагддаг

25.2%

Эрсдэлийн удирдлагын газартаа харьяалагддаг


18.9%

Хууль эрх зүйн нэгжид харьяалагддаг

15.3%


Комплайнсын бие даасан нэгжтэй

Зураг 3.1 Комплайнсын бие даасан нэгж



Зохицуулалттай салбар бүрт нийт судалгаанд оролцогчдын бие даасан нэгжийн хувь хэмжээг харуулав. Даатгагчдын 6.3 хувь, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ-ын 9.1 хувь, ХОМК-ийн 23.5 хувь нь бие даасан нэгжтэй буюу дундажаас бага байсан бол ВХҮҮ-ийн 63.6 хувь нь бие даасан нэгжтэй байна.

Зураг 3.2 Комплайнсын нэгж/ажилтны харьяалагдах газар, нэгж



Судалгаанд оролцогчдын 40.5 хувь комплайнсын нэгж/ажилтан нь эрсдэл болон хууль эрх зүйн хариуцсан нэгжээс бусад нэгжид харьяалагдаж байгаа нь олон улсын жишгээс өөр байгаа нь ажиглагдсан. Харин бие даасан комплайнсын нэгжтэй байгууллагын тоо нийт судалгаанд оролцогчдын 15.0 хувийг эзэлж байгаа харьцангуй бага үзүүлэлт байлаа. Ялангуяа, даатгагч болон итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ-уудын хувьд дунджаас бага үзүүлэлттэй байна.

Харин 11 ВХҮҮ судалгаанд оролцоноос 7 нь комплайнсын бие даасан нэгжтэй байна. Эндээс харьцангуй шинэ зохицуулалттай байгууллагууд бие даасан нэгжтэй байгаа нь ажиглагдаж байна. Цаашид бие даасан нэгжтэй байхын давуу тал, ашиг тусын талаар бусад байгууллагыг мэдээллээр хангах, хэрэгцээг ойлгуулах алхамууд хийх хэрэгтэй байгааг харуулж байна.

КОМПЛАЙНСЫН НЭГЖ/АЖИЛТНЫ ТАЙЛАГНАЛ

36.9%

Комплайнсын үйл ажиллагааны үр дүнгээ шууд удирдлагад тайлагнадаг

36.0%

Комплайнсын нэгж/ажилтан нь үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнадаг


20.7%

Судалгаанд дурдагдсан бүх этгээдэд үйл ажиллагаагаа тайлагнадаг

6.3%


Зөвхөн дотоод аудитын нэгжид тайлагнадаг, эсхүл одоогоор тайлагнаагүй

Зураг 3.3 Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ-уудын комплайнсын тайлагнал



Судалгаанд хамрагдсан нийт 66 итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ комплайнсын үйл ажиллагаагаа тайлагнасан байдлыг харвал, 42.4 хувь нь шууд удирдлагад, 30.3 хувь нь ТУЗ-д, 1.5 хувь нь дотоод аудитад тайлагнадаг бол 21.2 хувь нь дээр дурдсан бүгдэд зэрэг тайлагнадаг, харин 1.5 хувь нь одоогоор хэнд ч тайлагнаагүй гэсэн байна.

Зураг 3.4 Комплайнсын нэгж/ажилтан үйл ажиллагаагаа тайлагнадаг этгээд



Олон улсын тэргүүн туршлагаас харахад, комплайнсын нэгж/ажилтны үйл ажиллагаа хараат бус, бие даасан байх нь гүйцэтгэлийн үр дүнд шууд нөлөөлдөг тул үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнахыг зүйтэй гэж үздэг. Судалгаанд оролцогсдын 56.7 хувь нь ТУЗ-д үйл ажиллагаагаа тайлагнаж байгаа ба цаашид ТУЗ-д тайлагнах чиглэлд зохицуулалт оруулах эсвэл удирдамж өгөх хэрэгцээтэй байна.

КОМПЛАЙНСЫН НЭГЖ/АЖИЛТНЫ ЧИГ ҮҮРЭГ, БИЕ ДААСАН БАЙДАЛ

89.2%

Комплайнсын нэгж/ажилтан нь хараат бус, бие даасан чиг үүрэгтэй ба тэдгээрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь тодорхой байдаг гэсэн асуултанд оролцогсдын 32.4% нь бүрэн санал нийлж, 56.8% нь санал нийлсэн бол 5.4% нь мэдэхгүй гэж хариулсан

91.0%


Комплайнсын нэгж/ажилтан нь комплайнсын удирдлагыг бие даан хэрэгжүүлэх, тайлагнах үүрэгтэй гэдэгтэй санал нийлнэ

88.3%

Комплайнсын нэгж/ажилтны чиг үүрэг нь олон улсын стандарт, удирдамж, эрсдэлд суурилсан арга зүйд тулгуурлан тодорхойлогдсон гэдэгтэй санал нийлэх үү гэсэн асуултанд 26.1% нь бүрэн санал нийлнэ, 62.2% нь санал нийлнэ гэдгээ илэрхийлжээ

Зураг 3.5

Комплайнсын чиг үүрэг, бие даасан байдал



Комплайнсын нэгж/ажилтны чиг үүрэг, бие даасан байдлын талаарх асуултанд харьцангуй шинэ буюу 5 хүртэлх жил үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд комплайнсын нэгж/ажилтан хараат бус, бие даасан чиг үүрэгтэй, ажил үүрэг нь тодорхой, олон улсын стандартад тулгуурлан тодорхойлогдсон байдэг гэдэгтэй дийлэнх буюу 94.6 хувь нь санал нийлж байгаагаа илэрхийлжээ.

Хүснэгт 3.1 Комплайнсын нэгж/ажилтны чиг үүрэг, бие даасан байдал

Комплайнсын нэгж/ажилтны чиг үүрэг, бие даасан байдал	Бүрэн санал нийлнэ	Санал нийлнэ	Мэдэхгүй	Санал нийлэхгүй	Огт санал нийлэхгүй
Танай байгууллагын комплайнсын нэгж/ хариуцсан ажилтны чиг үүрэг нь олон улсын стандарт, удирдамж, эрсдэлд суурилсан арга зүйд тулгуурлан тодорхойлогдсон гэдэгтэй санал нийлэх үү.	26.1%	62.2%	10.8%	0.9%	0.0%
Танай байгууллагын комплайнсын нэгж/ хариуцсан ажилтан нь комплайнсын удирдлагыг бие даан хэрэгжүүлэх, тайлагнах үүрэгтэй гэдэгтэй санал нийлэх үү.	37.8%	53.2%	7.2%	1.8%	0.0%
Танай байгууллагын комплайнсын нэгж/ хариуцсан ажилтан хараат бус, бие даасан чиг үүрэгтэй ба тэдгээрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь нь тодорхой байдаг.	32.4%	56.8%	5.4%	4.5%	0.9%

Судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагууд комплайнсын нэгж/ажилтан нь олон улсын стандарт бүхий чиг үүрэгтэй, эрсдэлд суурилсан арга зүйд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг байх ёстой гэдэгтэй 88.3 хувь нь санал нийлж, 10.8 хувь нь мэдэхгүй гэсэн бол комплайнсын нэгж/ажилтан нь комплайнсын удирдлагыг бие даан хэрэгжүүлж, тайлагнах үүрэгтэй гэдэгтэй 91.0 хувь нь санал нийлж, 7.2 хувь мэдэхгүй гэж хариулсан. Харин байгууллагын комплайнсын нэгж/ажилтан нь хараат бус, бие даасан чиг үүрэгтэй, ажил үүргийн хуваарь нь тодорхой байх ёстой гэдэгтэй 89.2 хувь нь санал нийлсэн бол 5.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Цаашид санхүүгийн байгууллагуудын комплайнсын нэгж/ажилтны үйл ажиллагаа, ажил үүргийн хуваарь, тайлагналыг олон улсын стандарт, удирдамжийн дагуу боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

83.8%

Комплайнсын нэгж/ажилтны хяналт байгууллагын бүх үйл ажиллагааг бүхэлд нь хамардаг


8.1%

Комплайнсын нэгж/ажилтны үйл ажиллагаа байгууллагыг хэсэгчлэн хамардаг

7.2%


Шаардлагатай тохиолдолд л комплайнсын асуудлыг авч үздэг

Зураг 3.6 Комплайнсын үйл ажиллагаа компанийн үйл ажиллагааг бүхэлд нь хамрах хувь



Даатгалын салбарт комплайнсын хяналт нь байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь хамардаг гэж 100 хувь байгаа нь дундажаас өндөр, ВХҮҮ 72.7 хувь нь хамардаг гэсэн нь оролцогсдын дундажаас бага үзүүлэлттэй харагдана. Комплайнсын үйл ажиллагаа нь компанийн үйл ажиллагааг бүхэлд нь хамрах ач холбогдолтой юм.

Зураг 3.7 Комплайнсын нэгж/ажилтны үйл ажиллагааны хамрах хүрээ



Судалгаанд оролцогсдын 7.2 хувь нь комплайнсын чиг үүрэг бүхий ажилтнууд байгууллагын үйл ажиллагаанд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хяналт тавьдаггүй харин шаардлагатай тохиолдолд нь комплайнсын хяналтыг хэрэгжүүлдэг гэсэн нь анхаарал татаж байна. Комплайнсын нэгж/хариуцсан ажилтан байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь хамардаг байдал харьцангуй өндөр хувьтай байгаа боловч дээр дурдсанчлан шаардлагатай тохиолдолд л комплайнсын асуудлыг авч үздэг байгууллагуудад анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ.

КОМПЛАЙНСЫН НЭГЖ/АЖИЛТНЫ ТОО


80.2%

Комплайнсын чиг үүрэг бүхий 1 ажилтантай

18.9%


Комплайнсын чиг үүрэг бүхий 2-3 ажилтантай

Зураг 3.8 Комплайнсын чиг үүрэг бүхий 2-3 ажилтантай байгууллагын нийт ажиллагсдын тоо



Судалгаанд оролцсон нийт III байгууллагаас 21 нь комплайнсын чиг үүрэг бүхий 2-3 ажилтантай бол эдгээрээс 33.3 хувь нь 10 хүртэлх, 38.1 хувь нь 10-49, 28.6 хувь нь 50-249 ажиллагсадтай байна. Комплайнсын ажилтны тоо нь байгууллагын хэмжээнээс хамаарах хамаарал бага байна.

Зураг 3.9 Комплайнсын үйл ажиллагаа хариуцсан нэгж/ажилтны тоо



Комплайнсын үйл ажиллагааг хариуцсан 2-3 ажилтантай 21 байгууллага байгаагийн 14 нь буюу 66.7 хувь нь итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ, 4 нь буюу 19.0 хувь нь ВХҮҮ, 2 нь буюу 9.5 хувь нь ХОМК, 1 нь буюу 5.0 хувь нь даатгагч байгууллага байгаа юм.

Судалгааны үр дүнгээс харахад ихэнх нь комплайнсын чиг үүрэг бүхий 1 ажилтантай байгаа ба хэрэгжилт хангалттай гэж 60 хүрэхгүй хувь нь хариулж байсан тул комплайнсын ажилтныг чадваржуулах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах шаардлагатай гэж үзэж. Мөн комплайнсын үйл ажиллагааг өргөжүүлэх болон хамрах хүрээг нэмэгдүүлэх нь байгууллагад цаашид учирч болох томоохон эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтой гэдгийг таниулах үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.

КОМПЛАЙНСЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛҮҮД

Комплайнсын тогтолцоог сайжруулах зорилгоор зөвлөх үйлчилгээ, дэмжлэг авах талаар хамгийн их санал нийлсэн чиглэлүүд:

59.5%

Комплайнсын эрсдэлийг илрүүлэх арга зүй, технологийг хөгжүүлэх

55.9%

Комплайнсын хяналтын арга зүйг сайжруулах

47.7%

Комплайнсын аудит, үнэлгээ хийх арга зүйг сайжруулах

44.1%

Ажилтны мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ, дэмжлэг шаардлагатай

Зураг 3.10 ББСБ-ын комплайнсын тогтолцоог сайжруулах чиглэлүүд



Судалгаанд итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч нийт 66 ББСБ оролцсоноос комплайнсын тогтолцоог сайжруулах чиглэлээр 60.0 хувь нь комплайнсын эрсдэлийг илрүүлэх, технологио хөгжүүлэх, 56.1 хувь нь комплайнсын хяналтын арга зүйг сайжруулах, 54.5 хувь нь ажилтны мэдлэг, чадварыг хөгжүүлэх, 50.0 хувь нь комплайнсын аудит/үнэлгээ хийх арга зүйг сайжруулах гэж тодорхойлжээ.

Зураг 3.11 Комплайнсын тогтолцоог сайжруулах үндсэн чиглэлүүд



Нийт оролцогчдын 34.2 хувь нь комплайнсын бодлого ба тогтолцоог бүрдүүлэхэд, 32.4 хувь нь зохицуулалтын хяналт, шалгалтын чиглэлээр зөвлөх үйлчилгээ, дэмжлэг авах шаардлагатай гэсэн бол 3.6 хувь нь шаардлагагүй гэж хариулжээ. Комплайнсын тогтолцоог сайжруулахад зөвлөх үйлчилгээ, дэмжлэг шаардлагагүй гэж нийт 4 байгууллага хариулсны 2 нь ХОМК, 2 нь итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ ба эдгээр компаниуд 10 хүртэлх ажилтантай, 6-15 жил үйл ажиллагаа явуулж байгаа аж.

Судалгааны үр дүнд үндэслэн дэмжлэг авах шаардлагатай гэсэн чиглэлүүдээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, гарын авлага, сургалтын материалаар хангаснаар санхүүгийн байгууллагуудын комплайнсын тогтолцоог сайжруулахад ач холбогдолтой гэж дүгнэж байна.

КОМПЛАЙНСЫН НЭГЖ/АЖИЛТНЫ ОНЦЛОГ

51.4%

Комплайнс хариуцсан нэгж, ажилтны давуу тал нь хууль, эрх зүйн болон комплайнсын талаарх сайн мэдлэг, чадвар

24.3%

Комплайнсын эрсдэлийн үнэлгээ, аудит, дүн шинжилгээ хийх чадвар сайн

17.1%


Комплайнсыг хэрэгжүүлэх техник, практик туршлага сайн

Зураг 3.12 Даатгагч компанийн комплайнсын ажилтны онцлог



Даатгагч компаниудын комплайнсын ажилтны онцлогийг харуулсан. Нийт 16 даатгалын компани асуулгад оролцсоноос 8 нь комплайнсын ажилтны онцлог талыг хууль, эрх зүйн болон комплайнсын талаарх мэдлэг, чадвар сайн гэж дүгнэжээ.

Зураг 3.13 Комплайнсын нэгж/ажилтны онцлог



Судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагууд комплайнсын чиг үүрэг бүхий ажилтныг давуу талыг тодорхойлохдоо оролцогчдын 51.4 хувь нь хууль, эрх зүйн болон комплайнсын талаарх мэдлэг, чадвар нь гэж хариулсан бол 24.3 хувь нь комплайнсын эрсдэлийн үнэлгээ, аудит, дүн шинжилгээ хийх чадвар сайн гэж хариулжээ. Харин оролцогчдын 17.1 хувь нь комплайнсыг хэрэгжүүлэх техник чадвар, практик туршлага сайн гэж дүгнэсэн бол 7.2 хувь нь мэдэхгүй буюу тодорхойлж чадаагүй байна.

Санхүүгийн байгууллагын комплайнсын үйл ажиллагааг хариуцаж ажиллаж байгаа хүний нөөцийн өнөөгийн байдлаар үндэслээд эдгээр ажиллагсдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх боломж, хэрэгцээг тодорхойлох боломж гарч ирэх ач холбогдолтой.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТӨСӨВ

27.9%

Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд нийт төсвийн 1 хүртэл хувийг зарцуулдаг

15.3%

Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд нийт төсвийн 1-3 хувийг зарцуулдаг


4.5%

Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд нийт төсвийн 3-аас дээш хувийг зарцуулдаг

36.9%


Цаашид төлөвлөж байгаа

Зураг 3.14 Байгууллагын нийт төсвийн нэгээс дээш хувийг комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн байгууллагууд



Нийт оролцогчдоос 22 нь байгууллагын нийт төсвийн нэгээс дээш хувиар комплайнсын хяналтыг сайжруулахад төсөвлөсөн байна. Эдгээрээс 63.6 хувь нь ВХҮҮ, 35.3 хувь нь ХОМК, 12.1 хувь нь итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ байна.

Зураг 3.15 Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх төсөв



Нийт оролцогчдоос дийлэнх нь комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд байгууллагын нийт төсвийн 3 хүртэлх хувийг зарцуулж байна. Харин 37.0 хувь нь одоогоор төсөв батлаагүй, цаашид төлөвлөж байгаа нь харьцангуй өндөр хувьтай байна.

Харин 27.9 хувь нь нийт төсвийн 1 хүртэлх хувийг комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн бол 15.3 хувь нь мэдэхгүй гэжээ.

Энэ нь комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг батлуулахад байгууллагын удирдлагын зүгээс онцгойлон анхаарах шаардлагатайг харуулж байна.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Комплайнсын эрсдэлийг удирдахад тулгардаг сорилтууд:

55.9%

Комплайнсыг эрсдэлийг удирдах, хянах үйлдлийн автоматжуулалт

55.0%

Хурдацтай өөрчлөгдөж буй зохицуулалтын орчинд нийцэх

34.2%


Компанийн засаглал болон комплайнсын соёлыг бэхжүүлэх

Зураг 3.16 ХОМК-уудад тулгарч буй сорилтууд



Судалгаанд нийт 18 ХОМК оролцсоноос тэдгээр компаниудад тулгарч буй комплайнсын сорилтуудыг харуулсан. Үр дүнгээс харахад ХОМК-уудад хурдацтай өөрчлөгдөж буй зохицуулалтын орчинд нийцэж ажиллах, комплайнсыг удирдах, хянах үйлдлийн автоматжуулалтыг тулгарч буй гол сорилт, бэрхшээл гэдэгтэй санал нийлсэн байна.

Зураг 3.17 Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд тулгардаг сорилт, бэрхшээл



Дээр дурдагдсан хариултуудаас гадна нийт оролцогчдын 27.9 хувь нь байгууллагын бүх түвшинд нэгдсэн ойлголт өгөхийн тулд комплайнсын тайлан, мэдээллийн чанарыг сайжруулах, 20.7 хувь нь бусад нэгжүүдийн комплайнсын хариуцлагыг нэмэгдүүлэх, 16.2 хувь нь бодлого, эсхүл дүрэм, журам, стандартын нийцэлд хяналт тавих нь сорилт, бэрхшээл гэж хариулсан.

Судалгааны үр дүнгээр тодорхойлогдсон чиглэлүүдээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, хэрэгжүүлэх зөвлөмж гаргах нь эдгээр сорилт, бэрхшээлийг шийдвэрлэхэд тустай.

КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

Зохицуулалттай салбарын байгууллагуудаас комплайнсын эрсдэлийн удирдлагын үндсэн чиглэлүүдийг тодорхойлно уу гэхэд:

67.6%

Мөнгө угаах болон хориг арга хэмжээний эрсдэл

48.6%

Хууль эрх зүйн зохицуулалтууд

45.9%

Үйл ажиллагааны эрсдэл/Бизнесийн тасралтгүй байдал/Стратегийн эрсдэл ба хүний нөөцийн эрсдэл

37.8%

Мэдээллийн нууцлал ба кибер зохицуулалт

36.0%

Комплайнсын мэргэшсэн хүний нөөц

Зураг 3.18 ВХҮҮ-ийн комплайнсын эрсдэлийн удирдлагын үндсэн чиглэл



Судалгаанд оролцсон ВХҮҮ байгууллагуудын комплайнсын эрсдэлийн удирдлагын үндсэн чиглэлүүдийг харуулсан. ВХҮҮ байгууллагууд мөнгө угаах, хориг арга хэмжээ, хууль эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны эрсдэл, бизнесийн тасралтгүй байдал, стратегийн эрсдэл ба хүний нөөц, мэдээллийн нууцлалын эрсдэлийг комплайнсын эрсдэлийн удирдлагын онцлох чиглэлээр тодорхойлсон байна.

Зураг 3.19 Санхүүгийн салбар дахь комплайнсын эрсдэлийн удирдлагын үндсэн чиглэлүүд



Судалгаанд оролцогсад Зураг 3.18-д зааснаас гадна нэмэлтээр хяналт, шинжилгээ, тайлан боловсруулах, мэдээллийн ил тод байдал, хээл хахууль, хамтарч ажилладаг байгууллага, харилцагчидтай холбоотой нийцлийг комплайнсын эрсдэлд хамааруулдаг гэж хариулжээ.

Судалгааны үр дүнгээс харахад комплайнсын эрсдэлийн удирдлагыг мөнгө угаах гэмт хэргийн эсрэг үйл ажиллагаа, хориг арга хэмжээний хүрээнд авч үзэж байгаа байгууллага дийлэнх хувийг эзэлж байгаа тул комплайнсын бүрэлдэхүүн хэсгүүдийн талаарх ойлголтуудыг зохицуулалттай байгууллагуудад өгөх шаардлагатай нь харагдаж байна.

Хэсэг 4.

Хууль ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ



ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

45.9%

Хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмын нэгдсэн бүртгэл хөтөлж, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтөд тогтмол хяналт тавьдаг

28.8%

Комплайнсын нэгж, ажилтан хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмын бүртгэл, тэдгээрийн өөрчлөлтөд хяналт тавьдаг

19.8%

Хууль, дүрэм журмын нэгдсэн бүртгэл хийдэг ба хүлээсэн үүргээ өндөр түвшинд гүйцэтгэдэг

5.4%

Хууль, дүрэм журмын албан ёсны хяналт, зохицуулалт байхгүй

Зураг 4.1 Хууль, дүрэм журамд тасралтгүй хяналт тавьдаг



Судалгаанд оролцсон байгууллагуудын хууль, дүрэм журамд хяналт тавьж буй нөхцөл байдлыг харуулсан ба 45.9 хувь нь хууль, дүрэм журмын агуулгад гарч буй өөрчлөлтөд тасралтгүй хяналт тавьж ажилладаг гэжээ. Үүнээс ББСБ 52.9 хувь буюу хамгийн сайн, даатгагч 17.6 хувь, ВХҮҮ 15.7 хувь, ХОМК-ийн 13.7 хувь нь тогтмол тасралтгүй хяналт тавьж ажиллаж байна.

Зураг 4.2 Хууль, дүрэм журмын жагсаалт гаргаж, дагаж мөрдөж буй байдал



Хууль, дүрэм журмын албан ёсны хяналт, зохицуулалт огт байхгүй 5.4 хувь, тухайн байгууллагын комплайнсын чиг үүрэгтэй нэгж/хариуцсан ажилтанд 28.8 хувь нь төвлөрч, хамгийн их буюу 45.9 хувь нь тасралтгүй хяналт тавин ажилладаг гэжээ. Судалгаанд хамрагдсан нийт III байгууллагаас 19.8 хувь нь хүлээсэн үүргээ өндөр түвшинд гүйцэтгэдэг гэсэн үр дүн гарсан байна. Энэ нь салбарын зохицуулалтанд байгаа санхүүгийн байгууллагууд хууль, дүрэм журмаа харьцангуй сайн биелүүлж дагаж мөрддөг гэсэн дүгнэлтэд хүрлээ.

ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

63.1%

Санхүүгийн байгууллагад зөрчил гарах, сэжигтэй тохиолдол үүссэн бол судалж, шаардлагатай хариу арга хэмжээг яаралтай авдаг

33.3%

Өмнө гарсан зөрчлийг судалж, байгууллагын удирдлагад танилцуулан урьдчилан сэрэмж өгч ажилладаг


2.7%

Зөрчил гарсан эсэх болон хариу арга хэмжээ авах эсэхээ мэдэхгүй

0.9%

Зөрчилтэй холбоотой тодорхой арга хэмжээ авдаг

Зураг 4.3 Зөрчлийг судалж, шаардлагатай хариу арга хэмжээ яаралтай авдаг



Зөрчил гарсан тохиолдолд асуудлыг судалж, шаардлагатай арга хэмжээг 63.1 хувь нь яаралтай авдаг гэжээ. Энэ нь дунджаас дээш буюу сайжирч байна гэсэн үр дүн юм. Салбараар нь харуулбал, ББСБ 64.3 хувь буюу хамгийн сайн, ХОМК 15.7 хувь, даатгагч 12.9 хувь, ВХҮҮ 7.1 хувьтай судалгааны үр дүн гарчээ.

Зураг 4.4 Зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ



Зөрчил гарсан тохиолдолд арга хэмжээ авдаг, эсхүл мэдэхгүй гэж судалгаанд оролцогсдын 3.6 хувь нь хариулсан байна. Зөрчил, сэжигтэй үйл ажиллагааг таньж мэдэх талаар тогтмол сургалт хийх, зөвлөмж чиглүүлэг өгөх ажлыг тасралтгүй хангаж ажиллах хэрэгтэй байна. Зөрчилтэй холбоотой тодорхой бодит жишээ бүхий өгөгдөл дээр суралцах, мэргэших нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлнэ. Сургалт мэдээллээрээ кейс судалгаанд үндэслэн ойлголтыг нэмэгдүүлэх, арга зүйд нөлөө үзүүлэх агуулгын онол практикын мэдлэгтэй болгох нь давуу талыг бий болгоно.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ДОТООД ДҮРЭМ ЖУРМЫН ӨӨРЧЛӨЛТӨД ҮЗҮҮЛЖ БУЙ ХАРИУ ҮЙЛДЭЛ

58.6%

Хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлтийг дагаж, үйл ажиллагаандаа мөрдөж үнэлгээ хийж хяналт тавьдаг


34.2%

Холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын өөрчлөлтийг заримдаа үнэлгээ хийж, хяналт тавьж ажилдаг

7.2%

Хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлтийг огт мэдэхгүй, үйл ажиллагаандаа мөрдөж чаддаггүй

Зураг 4.5 Хууль тогтоомжийн бүртгэл хөтлөлт, хэрэгжилт



Хууль тогтоомжийн бүртгэл хөтлөлт, хэрэгжилтийг тогтмол үечилсэн үнэлгээ хийж, хяналт тавьдаг нь 58.6 хувьтай гарчээ. Салбараар харуулбал, ББСБ 60.0 хувь, ХОМК 16.9 хувь, даатгагч 12.3 хувь, ВХҮҮ 10.8 хувьтай байна.

Зураг 4.6 Хууль тогтоомж, дотоод дүрэм журмын өөрчлөлтөд үзүүлж буй хариу үйлдэл



Судалгаанд заримдаа үнэлгээ хийдэг, хяналт тавьдаггүй гэсэн 41.4 хувь байгаа харагдаж байна. Эдгээр байгууллагуудын хувьд үйл ажиллагааны ямар түвшинд хууль тогтоомжийн өөрчлөлт болон дотоод дүрэм журмын өөрчлөлт шаардлагатай байгааг илрүүлэх, цаашид сайжруулах талаас нь ямар ойлголт, зөвөлгөө сургалтаар хангаж ажиллах хэрэгцээг байгааг тодорхойлох хэрэгтэй ба зохих мэдээллийг хүргүүлж ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн байгууллагууд хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлтийг хангаж ажиллахын тулд тогтмол үнэлгээ хийх, тасралтгүй хяналт тавих шаардлагатай байдаг ба энэ нь эрсдэлээс сэргийлэх тогтолцоог дэмждэг юм.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ДОТООД ДҮРЭМ ЖУРМЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮРЭГ


64.0%

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлттэй холбоотой комплайнсын үүргээ тодорхойлж, шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг гэдэгтэй санал нийлнэ

29.7%


Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлттэй холбоотой комплайнсын үүргээ тодорхойлж, шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг гэдэгтэй бүрэн санал нийлнэ

Зураг 4.7 Хууль тогтоомж, дотоод дүрэм журмын үүрэг



Хууль тогтоомж, дотоод дүрэм журмын өөрчлөлттэй холбоотой үүргээ тодорхойлж, шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг гэдэгтэй санал нийлж байгаа гэж 94.0 хувь нь хариулжээ. Эндээс санхүүгийн салбарын хувьд хууль, тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн үүргээ тодорхойлж хэвшсэн гэж дүгнэхээр байна. Салбараар нь харуулбал, Үүнд ББСБ 62.0 хувь, ХОМК 19.7 хувь, даатгагч 11.3 хувь, ВХҮҮ 7.0 хувьтай үр дүн гарсан байна.

Зураг 4.8 Хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлттэй холбоотой үүрэг



Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 6.5 хувь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлттэй холбоотой комплайнсын үүргээ тодорхойлох, шинэчлэх үйл ажиллагааг мэдэхгүй, санал нийлэхгүй байгаа гэж хариулжээ. Салбарын зохицуулалт дах эдгээр байгууллагуудад зөвлөмж, чиглэл өгч хамтарч ажиллах шаардлагатай байна.

КОМПЛАЙНСЫН ТАЙЛАН

91.9%

Санхүүгийн байгууллага дотооддоо хуваарь гарган тайлан боловсруулах хөтөлбөртэй ба үүнийг албан ёсны ажил үүрэг болгож ажилладаг


6.3%

Тайлагнах хэд хэдэн шаардлагуудыг хангадаггүй бөгөөд эцсийн хугацааг хэтрүүлдэг

1.8%

Огт хяналт байхгүй 1.8 хувь

Зураг 4.9 Комплайнсын тайлангийн шаардлагын хариу үйлдэл



Комплайнсын тайлангийн шаардлага, хугацааг хянаж хариу үйлдэл үзүүлж албан ёсны ажил үүрэг болгон ажиллаж байгаа 91.9 хувь байна. Энэ нь судалгаанд хамрагдсан үр дүнгийн хамгийн их хувь юм. Зохицуулалт дах бусад байгууллагуудаас ББСБ 59.8 хувь, даатгагч 15.7 хувь, ХОМК 14.7 хувь, ВХҮҮ 9.8 хувьтай байна.

Зураг 4.10 Комплайнсын тайлан

1.Тийм - бид цаг тухайд нь шаардлагуудыг биелүүлэхийн тулд зохион байгуулалттай, автоматжуулсан хуваарь, тайлагнах хөтөлбөрийг албан ёсны ажил үүрэг болгож ажилладаг



2.Тийм - гэхдээ бид тайлагнах хэд хэдэн шаардлагуудыг хангадаггүй бөгөөд эцсийн хугацааг хэтрүүлдэг



3.Хяналт байхгүй



0.0% 10.0% 20.0% 30.0% 40.0% 50.0% 60.0% 70.0% 80.0% 90.0% 100.0%

Комплайнсын тайлагнах хэд хэдэн шаардлагуудыг хангадаггүй бөгөөд эцсийн хугацааг хэтрүүлэн хоцроодог ба хяналт тавьдаггүй гэж харьцангуй бага буюу 8.1 хувь нь хариулсан байна. Иймд зохицуулах байгууллагаас холбогдох дутагдалтай талуудыг илрүүлэх, шаардлагатай арга хэмжээг цаг алдахгүй авах үйл ажиллагааг зохион байгуулж замаар хугацаандаа, стандартад нийцсэн тайлан авах боломжоо нэмэгдүүлнэ юм. Мөн тайлангийн шаардлагуудыг танилцуулах, тайлбарлах сургалт, мэдээллээр хангаж, хяналт бий болгох замаар хугацаандаа ирүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллах хэрэгтэй юм.

КОМПЛАЙНСЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, НӨЛӨӨ

39.6%

Ажилтнууддаа зориулсан комплайнсын заавар журмын санал авч, хөтөлбөртөө тусгаж ажилладаг


20.7%

Комплайнсын сургалтын үнэлгээ хийдэг

7.2%

Комплайнсын өөрийн үнэлгээний системтэй

Зураг 4.11 Комплайнсын хөтөлбөр ба үр дүн



Ажилтнууддаа зориулсан комплайнсын заавар журам ба сургалтын үнэлгээг 60.3 хувь нь хөтөлбөртөө тусган ажиллаж байна. Салбараар нь харуулбал ББСБ 65.9 хувь, ХОМК 13.6 хувь, даатгагч 11.4 хувь, ВХҮҮ 9.1 хувьтай байна.


Зураг 4.12 Комплайнсын хөтөлбөрийн үр дүн, нөлөө



Комплайнсын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг үнэлэхийн тулд зөвхөн сургалтанд хамрагдсан байдал болон ажилтнуудаас санал асуулга авах нь учир дутагдалтай ба комплайнсын үнэлгээний тайланг зөвхөн 4.5 хувь нь хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлжээ. Иймд дотоод болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх хэрэгцээ шаардлагатай байгаа нь харагдаж байна. Зохицуулагч байгууллага алдаа зөрчлийг илрүүлэх зарчмаар цаашид торгууль ногдуулах, цаашид үйл ажиллагааг тасралтгүй сайжруулхад нь дэмжих зорилготой хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлсэн арга хэмжээг нь үнэлэх дүгнэж ажиллах нь чухал юм.

Хэсэг 5.

**Комплайнсын
хяналтын
технологийн
шийдэл, техник
арга зүй,
сургалтын
хөтөлбөр**



КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

64.9%

Комплайнсын эрсдэлийг удирдах технологийн шийдлийг ашигладаггүй


13.5%

Комплайнсын эрсдэлийг удирдахар дотооддоо цахим хөгжүүлэлтийг хийж байна

9.0%

Комплайнсын эрсдэлийг удирдахдаа онлайн цахим шийдэл ашигладаг

Зураг 5.1 Комплайнсын технологийн шийдэлгүй байдал



Комплайнсын эрсдэлийг удирдахад технологийн шийдлийг ашигладаггүй гэж нийт оролцогчдын 64.9 хувь нь хариулсан ба цаашид технологи хөгжүүлэх, дэмжих шаардлага байгааг хариуулж байна. ББСБ-ийн 69.4 хувь, ВХҮҮ-ийн 2.7 хувь, даатгагчдын 11.1 хувь, ХОМК-ийн 16.6 хувь нь комплайнсын удирдлагад технологийн шийдлийг ашигладаггүй байна.

Зураг 5.2 Комплайнсын хяналтын технологийн шийдэл



Орчин үед комплайнсын эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд технологийн шийдлийг ашиглах хандлага бий болсон ба энэ нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлэх юм. Санхүүгийн байгууллагуудын 64.9 хувь технологийн шийдэл ашиглахгүй байгаа тул ямар боломж, шийдэл байж болох талаар судалгаа шинжилгээ хийх хэрэгцээ харагдаж байна. Жишээ нь технологийг ашиглан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг нэгдсэн бүртгэл мэдээллийн системээр дамжуулан хяналт хийж ажиллах бүрэн боломжтой байна.

КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТЕХНИК АРГА ЗҮЙ

35.1%

Комплайнсын эрсдэлийг удирдахдаа техник арга зүйг огт ашигладаггүй

18.9%

Комплайнсын асуудал, кейс гарсан бол бүртгэдэг


18.0%

Комплайнсын эрсдэлийн үнэлгээ ба хяналт шалгалт байхгүй

10.8%

Комплайнсын сургалтыг зохион байгуулдаг

Зураг 5.3 Комплайнсын эрсдэлийн удирдлагад ашиглаж буй технологийн шийдэл



Комплайнсын эрсдэлийг удирдлагад ББСБ-ын 57.6 хувь, даатгагчдын 20.9 хувь, ХОМК 20.9-ийн хувь нь ямар нэгэн техник арга зүй ашигладаггүй гэжээ.

Зураг 5.4 Комплайнсын эрсдэлийг удирдахдаа техник арга зүйн ашиглалт



Комплайнсын эрсдэлийг удирдахдаа техник арга зүй ашиглах нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлдэг ба судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагуудын 35.1 хувь техник арга зүй огт ашигладаггүй гэсэн байгаа нь цаашид эрсдэлээ удирдахдаа техник арга зүй ашиглах олон улсын шилдэг, сайн туршлага судалж өөрийн улсын нөхцөлд хөгжүүлэх боломж бүхий техникийг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байгаа гэсэн дүгнэлтэд хүрлээ.

КОМПЛАЙНСЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

27.9%

Комплайнсын мэргэжилтэн болон ажилтнуудаа сургалтанд хамруулсан


19.8%

Харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдалтай холбоотой сургалтад ажилтнуудаа хамруулсан

15.3%

Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтанд хамруулсан

Зураг 5.5 Сүүлийн 12 сарын хугацаанд хамруулсан сургалт



Сүүлийн 12 сарын хугацаанд судалгаанд хамрагдсан III байгууллагуудаас 42 байгууллага комплайнсын мэргэжилтэн бэлдэх сургалтанд хамрагдсан байна. Үүнд ББСБ 64.3 хувь, ВХҮҮ, даатгагч, ХОМК тус бүр 11.9 хувь хамрагдсан үр дүн гарсан байна.

Зураг 5.6 Комплайнсын сургалтын хөтөлбөр



Комплайнсын мэргэжилтний болон ажилтны сургалтанд дийлэнх буюу 27.9 хувь нь хамрагдсан байгаа ба бусад хээл хахууль, авилгын эсрэг 13.5 хувь, мэдээллийн нууцлалын сургалтанд 19.8 хувь нь хамрагдсан байгаа нь салбарын зохицуулалтын санхүүгийн байгууллагууд тасралтгүй суралцаж, ойлголт мэдээлэл нэмэгдэж байгааг үр дүн сайжирч байна гэж дүгнэж байна.

Цаашид харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй харилцагч төлбөр тооцоог таньж мэдээд мэдээлэх үүргийн хүрээнд олон улсын мэргэшсэн болон дотоодын нарийн мэргэжлийн сургалтанд тасралтгүй хамруулах хэрэгцээ байна.

Судалгаанд хамрагдсан нийт 111 санхүүгийн байгууллагуудаас 64.0 хувь нь компанийн засаглалын, 59.0 хувь нь комплайнсын тогтолцоо бүрдсэн гэдэгтэй санал нийлжээ.

Шигтгээ: ВХҮҮ-ийн салбарт комплайнсын тогтолцооны бүрдэлт зохицуулалтын нөхцөл шаардлагатай холбоотойгоор бусад салбартай харьцуулахад харьцангуй өндөр буюу 70 гаруй хувьтай байна.

Комплайнсын хөтөлбөр, ажлын төлөвлөгөөг нийт судалгаанд оролцогсдын 50.0 хувь нь хэрэгжүүлдэг.

Шигтгээ: Комплайнсын хөтөлбөр, ажлын төлөвлөгөө нь комплайнсын хяналтын суурь хүчин зүйл бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд санхүүгийн болон хүний нөөц голлох нөлөөг үзүүлдэг аж.

Судалгаанд оролцогчдын 80 орчим хувь нь комплайнсын нэг ажилтантай, 15.0 хувь нь бие даасан нэгжтэй, үлдсэн хэсэг нь энэхүү чиг үүргийг бусад албан тушаалтай давхардуулан гүйцэтгүүлж байна.

Шигтгээ: Санхүүгийн салбарт комплайнсын үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор зохицуулагч байгууллага болон мэргэжлийн холбоодтой хамтран сургалтын материал, гарын авлага боловсруулах, сургалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах нь комплайнсын эрсдэлийг удирдахад чухал ач холбогдолтой.

Санхүүгийн байгууллагуудын 80 орчим хувь нь ТУЗ-ийн түвшинд комплайнсын эрсдэлээ хэлэлцдэг тогтолцоотой.

Шигтгээ: Санхүүгийн салбарт комплайнсын хяналтыг тухайн байгууллагын дээд удирдлагын түвшинд хэлэлцэж, ач холбогдол өгч байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагууд комплайнсын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд учирч буй гол бэрхшээл нь хяналтын процессыг автоматжуулах, зохицуулалтын өөрчлөлтөд үйл ажиллагаагаа нийцүүлэх.

Шигтгээ: Санхүүгийн байгууллагад тулгарч болох бэрхшээлийг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг тогтмол үнэлэх тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон зохицуулалтын орчны өөрчлөлт, түүний мөн чанарыг таниулах ажлыг зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой.

Комплайнсын тогтолцоог сайжруулахад нэгд, комплайнсын эрсдэлийг илрүүлэх, хоёрдугаарт, комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх, гуравдугаарт, комплайнсын аудит, үнэлгээ хийх арга зүйг сайжруулах хэрэгцээтэй гэжээ.

Шигтгээ: Комплайнсын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах нь үр дүнд хүрэх аж.

Комплайнсын эрсдэлийг удирдаж буй сайн туршлагаас харахад, технологид суурилсан чиг хандлага ажиглагдаж байна.

Шигтгээ: Технологийн оновчтой шийдлийг олох, комплайнсын зардлыг бууруулах зорилготой төр, хувийн хэвшил, сургалт, судалгааны байгууллагуудын хамтарсан судалгаа шинжилгээ нь санхүүгийн салбарт комплайнсын зохистой тогтолцоог бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлэгч хүчин зүйл болно.

Санхүүгийн зохицуулах хороо

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот,
Монгол улс 15160

info@frc.mn

[51-264444](tel:51-264444)

**Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбар дахь
комплайнсын тогтолцооны өнөөгийн байдал**